Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана”, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т тус тус заасны дагуу 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Д.Луттөмөр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 3 дугаар сарын 08-аас 2022 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь аудитын газрын аудитор Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, ахлах аудитор Г.Намчинсүрэн хариуцаж гүйцэтгэв.

2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/39 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хишиг-Өндөр сумын засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Хишиг-Өндөрчүүд бид орон нутагтаа элбэг хангалуун, аз жаргалтай, эрх чөлөө, эрдэм боловсролтой, урам зоригтой ажиллаж ХҮСЭЛ ТЭМҮҮЛЭЛТЭЙ, БАЯЛАГ БҮТЭЭГЧ ӨРХ ГЭРИЙГ ХАМТДАА БҮТЭЭХ-ийг зорино” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн үйлчилгээг иргэдэд тэгш, хүртээмжтэй хүргэх эвсэг, чадварлаг, мэргэшсэн хамт олныг бүрдүүлэн, орон нутгаа хөгжүүлэх
- Орон нутгийн онцлогт тохирсон хөгжлийн бодлого боловсруулан, хэрэгжүүлж иргэдийн итгэлийг хүлээсэн манлайлагч захиргааны байгууллага болох
- Сумын хүн ам, ХХАА-н үйлдвэрлэл, үйлчилгээний бүртгэл судалгааг хөтөлж, дээд шатны байгууллагыг мэдээ мэдээллээр хангах;
- Оновчтой төлөвлөлт хийж, гүйцэтгэлийн үр нөлөө, бүтээмжийг дээшлүүлж, сум орон нутгийнхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийн тогтвортой ахиулах замаар иргэдийнхээ хөгжих боломжийг хангаж, амьдрах таатай орчин бүрдүүлэхэд чиглэн, төрийн үйлчилгээг стандартад нийцүүлэх чанартай хүргэнэ

Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хишиг-өндөр сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас харьяа төсвийн шууд захирагчдын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хишиг-Өндөр сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, ажил гүйлгээг аккрузель сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,699.0 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 93.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 75.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 129.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 267.6 сая төгрөг болж, 137.7 сая төгрөгөөр буюу 106.0 хувиар өссөн байна.

<i>Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл</i>				
<i>/сая төгрөг/</i>				
<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
<i>Төрийн сангийн харилцах дансанд</i>	<u>129.9</u>	<u>267.6</u>	<u>137.7</u>	<u>100.0</u>
Нийт дүн	<u>129.9</u>	<u>267.6</u>	<u>137.7</u>	<u>100.0</u>
Үүнээс байгууллагаар	-	-	-	-
ОНЕО	<u>64.3</u>	<u>113.5</u>	<u>49.2</u>	<u>42.4</u>
ОНХС	<u>13.8</u>	<u>35.8</u>	<u>22</u>	<u>13.4</u>
СХС	<u>43.5</u>	<u>106</u>	<u>62.5</u>	<u>39.6</u>
БХС	<u>6.9</u>	<u>5.3</u>	<u>-1.6</u>	<u>2.0</u>
ЖДҮДС	<u>1.7</u>	<u>1.3</u>	<u>-0.4</u>	<u>0.5</u>
ЭМТ	-	<u>5.6</u>	<u>5.6</u>	<u>2.1</u>
Нийт дүн	<u>130.2</u>	<u>267.5</u>	<u>137.3</u>	<u>100</u>
<i>Эх сурвалж: Хишиг-Өндөр сум-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан</i>				

Төрийн сангийн харилцах дансанд тайлант оны эхэнд мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө нь тайлант оны эхэнд 129.9 сая төгрөг байснаас оны эцэст 267.6 сая төгрөг болж 137.7 сая төгрөг буюу 106 хувиар өссөн нь сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл 62.5 сая төгрөг, орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 49.2 сая төгрөг, ОНХС-гийн хөрөнгө 22.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ихээхэн нөлөөлсөн байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 267.6 сая төгрөг арилжааны дансанд, 5.6 сая төгрөг ЭМТ-ийн төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансанд байршиж байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 364.4 сая төгрөг болж 105.8 сая төгрөгөөр буюу 40.9 хувиар өссөн байна.

<i>Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл</i>			
<i>/сая төгрөг/</i>			
<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>
Ажиллагчидтай холбогдсон авлага		0.6	0.6
Татаас, санхүүжилтийн авлага		130.6	130.6
Зээлийн хүүгийн авлага	2.0	1.6	-0.4
Байгууллагаас авах авлага	21.3	47.9	26.6
Хув хүмүүсээс авах авлага	235.3	183.7	-51.6
Дүн	258.6	364.4	105.8
Үүнээс байгууллагаар			
ОНЕО	2.4	2.4	0.0
СХС	215.9	161.95	-53.9
ЖДҮДС	10.0	10.1	0.1

ЗДТГ	20.8	25.9	5.2
ЕБС	0.7	32.88	32.2
СӨБ	8.9		-8.9
ЭМТ		131.2	131.2
Дүн	258.6	364.4	105.9

Эх сурвалж: Хишиг-Өндөр сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын эцсийн үлдэгдэл 364.4 сая төгрөг болж 105.8 сая төгрөг буюу 40.9 хувиар өссөн нь ЭМТ-ийн 10, 11, 12-р сарын ковидтой холбоотой эрүүл мэндийн даатгалаас санхүүжих 131.2, ЕБС-ийн оны эцэст хөрөнгө бэлтгэх зорилгоор 32.2 сая төгрөгийн авлага үүсгэсэн нь нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 20.5 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Сум хагжүүлэх сангийн Эргэн төлөгдөх зээлийн хугацаа хэтэрсэн 18.1 сая төгрөгийн авлага;
- ОНЕО дансанд 1995 онд үүссэн эзэн холбогдогчгүй 2.4 сая төгрөгийн авалага тус тус байна.

Аудитын илрүүлэлт:

- Сум хөгжүүлэх сангийн авлагын журналын бичилтийг аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захирамжаар батлагдсан НБББББ-ын 4.5-д заасны дагуу бүртгээгүй, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын хавсралтын 5.3.1, НББ-ийн тухай хуулийн 20.2.5, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтын НХМаягт ТМ-3, оршин байх батламж мэдэгдлийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. /Сум хөгжүүлэх сан 157.0 сая/
- Тайлант хугацаанд тооцооллыг тухай бүр хийгээгүйгээс 0.5 сая төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна./ЭМТ 0.5 сая/
- Харилцагч байгууллага Е баримт дутуу шивсэн, тооцоо нийлж үлэгдлийг баталгаажуулаагүй, харилцагч байгууллагуудаас 10 дээш гүйлгээ хийсэн харилцагч байгууллагуудыг түүвэрлэн тулгахад тооцооны үлдэгдлийг баталгаажуулаагүй нь ННБ-ийн тухай хуулийн 20.2.5, 20.2.6 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна./ЗДТГ 4.0 сая/

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эцсийн үлдэгдэл 415.0 сая төгрөг болж, 14.8 сая төгрөгөөр буюу 10.2 хувиар буурсан байна.

Хүснэгт № 3 Бараа материалын үлдэгдэл		/сая төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	
Тусгай зориулалттай материал	102.2	101.5	-0.7	
Эм боох материал	2.2	46.3	44.1	
Бичиг хэргийн материал	4.9	4.1	-0.8	
Аж ахуйн материал	169.4	198	28.6	
Сэлбэг хэрэгсэл	26.8	13.1	-13.7	
Түлш, шатах тослох материал	0.5	3.7	3.2	
Барилгын засварын материал	25.3	0.3	-25	

Хүнсний материал	3.4	5.7	2.3
Бусад хангамжийн материал	54.2	12	-42.2
Мал амьтад	41.5	20.4	-21.1
Нөөцийн бараа		10.5	10.5
Дүн	430.4	415.6	-14.8

Эх сурвалж: Хишиг-Өндөр сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын орлого нь худалдан авсан 415.0 сая төгрөг, хандиваар 262.6 сая төгрөг, шилжүүлэн авсан 59.9 сая төгрөг, бусад 23.06 сая төгрөгийн бараа материалаас бүрдэж байна. Эмнэлгийн санхүүгийн тайлан энэ онд сумын нэгтгэлд орж байгаатай холбогдон шилжүүлэн авсан бараа материал 45.4 сая төгрөгөөр нэмэгдсэн. Мөн сургууль бусад хангамжийн материалаас 13.2 сая төгрөгийн, барилгын материалаас 0.5 сая төгрөгийн бараа материалыг зориулалт, шинж чанарыг нь үнэлэн аж ахуйн бараа материалд шилжүүлэн авч 14.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Бараа материалын зарлага нь худалдсан зарцуулсан 749.5 сая төгрөг, шилжүүлсэн 14.6 сая төгрөг, бусад 11.3 сая төгрөгийн бараа материалаас бүрдэж байна. Ерөнхий боловсролын сургууль 14.5 сая төгрөгийн бараа материалыг данс хооронд шилжүүлсэн.

Бараа материалын үлдэгдэлд тайлант оны эцэст эмнэлэг 46.3 сая төгрөгийн эм боох материал, бичиг хэргийн материал 4.1, тусгай зориулалтын материал 101.5 сая төгрөг, түлш, шатах тослох материал 3.7 сая төгрөг, аж ахуйн материал 198.0 сая төгрөг, сэлбэг хэрэгсэл 13.1 сая төгрөг, барилгын засварын материал 0.3 сая төгрөг, хүнсний материал 5.7 сая, бусад хангамжийн материал 12.0 сая төгрөг, мал амьтад 20.4 сая төгрөг, нөөцийн бараа 10.5 сая төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- *ЭМГ-аас ирсэн бараа материалыг тухай бүр орлогод авсан ч ЭМГ-тай тооцоо нийлсэн актгүй байна.*
- *Тооллогыг ЭМТ-ын даргын А/20 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй комисс томилогдон 12 дугаар сарын 30-нд тооллогыг хийж дууссан бөгөөд тооллого хийгдсэнээс хойш 24,629.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, бараа материалын хувьд 522.5 мянган төгрөгийн орлого, 12,953.1 мянган төгрөгийн зарцуулалт хөдөлгөөн хийгдсэн ч тооллогын дүн 12 дугаар сарын 31-ний үлдэгдлээр тоологдсон, 8,829.1 мянган төгрөгийн вакцин тоолсон баримт байхгүй нь тооллогыг үнэн зөв, бодиттой хийгээгүй нь оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.*

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 8,674.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 10,442.7 сая төгрөг болж 1,768.1 сая төгрөгөөр буюу 20.3 хувиар өссөн байна.

<i>Хүснэгт № 4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл</i>	<i>/сая төгрөг/</i>		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	6,728.1	8,121.1	1,393.0
Авто-тээврийн хэрэгсэл	202.7	269.1	66.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	398.5	622.3	223.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	318.4	362.2	43.8
Зам, гүүрийн байгууламж	16.8	26.3	9.5
Бусад үндсэн хөрөнгө	756.1	768.8	12.7
Дуусаагүй барилга, байгууламж	59.0	59.0	0.0

Ном	50.4	50.7	0.3
Програм хангамж	4.3	5.6	1.3
Бусад биет бус хөрөнгө	140.3	157.6	17.3
Дүн	8,674.6	10,442.7	1,768.1

Эх сурвалж: Хишиг-Өндөр сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 115.34 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч хандиваар 34.77 сая төгрөг хөрөнгө бэлтгэж 1,602.5 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч бусад газраас 15.66 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Энэ шилжүүлэн авсан хөрөнгө нь эмнэлгийн тайланг шинээр нэгтгэж байгаатай холбоотой байна. Тайлант хугацаанд 310.03 сая төгрөгийн элэгдэл тооцсон байна. Мөн эмнэлгийн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 892.60 сая төгрөгийг өмнөх оны элэгдлийн зөрүүгээр тусгасан.

Мөн хөрөнгийн үлдэгдэл 1,768.1 сая төгрөг буюу 20.3 хувиар өссөн нь 34.3 сая төгрөгийн хөрөнгө хандиваар, эмнэлгийн шилжүүлэн авсан 1,602.52 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн зэрэг нь шууд нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өргөө нөхсөн 0 төгрөгийн дансны үнэтэй 13.4 сая төгрөгийн 37 хөрөнгийг тайлагнасан байна. Энэ нь УСНББОУС-17, Засгийн газрын 2006 оны 388 дугаар тушаалын нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.41-т "Биет хөрөнгийн дансны үнэ бодит үнээс материаллаг хэмжээний зөрүүтэй байх нөхцөлд хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна. /СӨБ/
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг мөрдлөгө болгож ажиллаагүй нийт 7.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн./ИТХ/

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 5.1 сая төгрөг болж шинээр үүссэн байна.

<i>Хүснэгт № 5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл</i>				<i>/сая төгрөг/</i>
Үзүүлэлт	Эхний	Эцсийн	Өссөн+	Дүнд эзлэх
	үлдэгдэл	үлдэгдэл	Буурсан -	
Байгууллагад төлөх өглөг	-	0.5	0.5	9.8
Хувь хүмүүст төлөх өглөг	-	4.6	4.6	90.2
Нийт дүн	-	5.1	5.1	100.0
Үүнээс байгууллагаар	-	-	-	-
ЗДТГ	-	4.6	4.6	90.2
ЭМТ	-	0.5	0.5	9.8
Нийт дүн	-	5.1	5.1	100.0

Эх сурвалж: Хишиг-Өндөр сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаанд өр төлбөрийн үлдэгдэл 5.1 сая төгрөг болсон нь ЗДТГ-т төрөөс цэвэр усны төлбөрийг хариуцаж байгаатай холбогдон Булган Мээж ХХК-аас 4-р улирлын усны төлбөр орж ирээгүйн улмаас худгуудад олгох 4.6 сая төгрөг, эм, эмийн хэрэгслийн 0.5 сая төгрөгийг дутуу төлснөөс шалтгаалсан байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,835.8 сая, эцсийн үлдэгдэл 4,631.9 сая төгрөг болж, 796.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1342.1	1756.1	414	23.57
Хуримтлагдсан үр дүн	-28.8	-99.8	-71	71.14
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2522.5	2975.6	453.1	15.23
Дүн	3,835.8	4,631.9	796.1	17.2

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1756.1 сая төгрөг болж 414.0 сая төгрөгөөр өссөн нь эрүүл мэндийн тайлан тус сумын тайланд нэгтгэгдэж байгаагаас шалтгаалжээ. Үүнд: Үндсэн хөрөнгийн өсөлт 413.9 сая төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 2,975.6 сая төгрөг болж тайлант онд 453.1 сая төгрөгийн өөрчлөлт орсон байна.

Хуримтлагдсан үр дүн 99.8 сая төгрөг болж 71.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалжээ.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга тайлант онд хийгдээгүй байна.

3.5.10 Орлогын данс

Хишиг-Өндөр сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 11 дугаар тогтоолд тайлант онд 113.9 сая төгрөгийн орлого улсын /орон нутгийн/ төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 208.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 182.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №7 Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
УРСГАЛ ОРЛОГО	113.86	208.30	94.44	182.94
ТАТВАРЫН ОРЛОГО	96.96	187.20	90.24	193.07
Орлогын албан татвар	56.50	64.40	7.90	113.98
Үйл ажиллагааны орлого	2.50	32.10	29.60	1284.00
Хадгаламжийн хүүгийн орлого	28.00	27.80	(0.20)	99.29
Суутгагчийн орлогын албан татвар	26.00	4.50	(21.50)	17.31
Өмчийн татвар	3.66	95.40	91.74	2606.56
Бууны татвар	3.66	4.00	0.34	109.29
Малд ноогдуулах албан татвар		91.40	91.40	
Бусад татвар	36.80	27.40	(9.40)	74.46
Улсын тэмдэгтийн хураамж	6.00	6.60	0.60	110.00
Газрын төлбөр	2.40	2.90	0.50	120.83
Ойгоос хэрэглээний мод түлээ ашигласны төлбөр	14.20	13.20	(1.00)	92.96
Ус ашигласны төлбөр	0.18	0.18	-	100.00
ТүгээмэлТархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	10.00	0.74	(9.26)	7.40
Хог хаягдал	4.00	3.70	(0.30)	92.50
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16.90	21.10	4.20	124.85
Хүү торгуулийн орлого	13.00	15.80	2.80	121.54
Төсөвт газрын өөрийн орлого	3.95	5.30	1.35	134.18
Нийт дүн	113.86	208.30	94.44	182.95

Орлого 94.5 сая төгрөгөөр давсан нь 91.4 сая төгрөгийн малд ноогдуулах албан татварыг орон нутгийн орлогоор төлөвлөөгүй, хүү торгуулийн орлогод хууль бус мод бэлтгэлийн торгууль, нөхөн төлбөр орсноос шалтгаалсан байна.

3.5.11 Зардлын данс

Зардлын данснудтай холбоотой 504.1 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Тухайлбал:

- *Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4, 1.6, 1.7 дэх заалтыг зөрчсөн. /ЗДТГ 6.4 сая төгрөг, ИТХ 7.5 сая, Сургууль 11.1 сая/*
- *Батлагдсан орон тоо, төсөвт батлагдаагүй тусгаагдаагүй орон тоог бий болгохж цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" тухай заалт, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. /ЗДТГ 6.2 сая төгрөг, Соёлын төв 0.7 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 0.3 сая/*
- *Засаг даргын нөөц хөрөнгийг журамд нийцээгүй нийт 3.3 сая төгрөгийг зарцуулж Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 1.1 дэх заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн ба зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна. /ЗДТГ/*
- *Цалингийн зардлаас Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийг бүлэг хооронд 3.1 сая төгрөгийг шилжүүлэн төлсөн. /ЕБС/*
- *Бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас Хаан банкны хуучин тавилгаас 0.4 сая төгрөгөөр 2 ширээ, 3 тек, 1.1 сая төгрөгний 2 зурагт зэрэг хөрөнгө бэлтгэсэн нь Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" хавсралтыг зөрчсөн байна. /ЕБС/*
- *Шатахууны тооцоо хийгдээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу 0.1 сая төгрөгийг зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 13.13.6, 13.7 дахь заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна. /СӨБ/*
- *ИТХ-аар зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй хийгдээгүй ажлыг төлөвлөж батлуулсан нь Төсвийн тухай хуулийн 29.4 дүгээр заалтыг зөрчсөн. ИТХ-аар баталж 58.1 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтын 43.2-43.4-д заасныг зөрчсөн байна. /ОНХС /*
- *Зам засварын ажлын гэрээнд тусгайлан заагүй шатахууны зардал 956.0 мянган төгрөгийг гүйцэтгэгч байгууллагын өмнөөс төлж гэрээнд заагдаагүй зардлыг шилжүүлсэн. /ОНХС/*
- *Тайлант онд ОНХС-гаас нийт 15.0 сая төгрөгийн хөрөнгийг бэлтгэж бусад холбогдох байгууллагад шилжүүлэхдээ аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захирамжаар батлагдсан НБББББ-ын 4.6, тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна./ОНХС/*

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын /орон нутгийн / төсвийн орлого бүрдүүлэлт

Тайлант онд 112.0 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого төсөвт төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 165.2 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 53.2 сая төгрөгөөр буюу 147.5 хувиар биелүүлсэн.

Хүснэгт №8 үндсэн үйл ажиллагааны орлого хүснэгтээр				мян төг	
Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
Сургууль		2.7	2.7	0.0	
Цэцэрлэг		3.0	3.0	0.0	
ЗДТГ	4.0	5.4	1.4	135.4	
МСТөв	1.3	1.1	-0.2	84.6	
сум хөгжүүлэх сан	76.5	137.6	61.1	179.9	
байгал хамгаалах сан	30.2	15.5	-14.7	51.3	
дүн	112.0	165.2	53.2	147.6	

Сум хөгжүүлэх сангийн орлого 61.1сая, Засаг даргын тамгын газрын орлого 1.4 сая, төгрөгөөр давж орсон боловч байгаль хамгаалах сангийн орлого 14.6 сая төгрөгөөр тасарсан зэргээс шалтгаалжээ.

Туслах үйл ажиллагааны орлого 0.4 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 0.4 сая төгрөгөөр давсан нь авлага барагдуулсанаас шалтгаалжээ.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3797.1 сая төгрөгөөр, нийт зарлагыг 3797.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 391.0 сая төгрөгөөр бууруулж 3456.1 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь нийт урсгал зардлыг бууруулж баталсан байна.

Хүснэгт№ 9 Батлагдсан төсөв

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Зөрүү
ИТХурал	85.0	82.9	2.1
ЗДТГ	438.0	415.7	22.3
МСТөв	159.7	140.6	19.1
Хишиг-Өндөр СЭМТ	723.2	694.3	28.9
Сургууль	1,721.4	1,523.7	197.7
Цэцэрлэг	489.5	378.6	110.9
Сум хөгжүүлэх сан	120.0	120.0	-
Байгал хамгаалах сан	37.1	37.1	-
Орон нутгийн хөгжлийн сан	73.2	63.2	10.0
дүн	3,847.1	3,456.1	391.0

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 32 хөтөлбөрт зориулан 3456.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 3273.0 сая төгрөгийг урсгал зардалд, 63.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 120.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2153.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 992.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс 69.2 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 128.5 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 112.0 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт№ 10 Төсвийн гүйцэтгэл байгууллагаар

/сая төгрөг/

Хишиг-Өндөр сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Улсын төсөвт төвлөрүүлсэн	Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн
Сургууль	1523.7	1474.0	-49.7	96.7	50.61	0
Цэцэрлэг	378.6	357.1	-21.6	94.3	24.37	0
СЭМТ	694.3	637.7	-56.6	91.8		
ИТХ	82.9	79.2	-3.7	95.5		3.2
ЗДТГ	415.7	400.5	-15.2	96.3		10.9
МСТөв	140.6	139.1	-1.6	98.9		1.3
сум хөгжүүлэх сан	120.0	75.2	-44.8	62.6		
байгал хамгаалах сан	37.1	17.2	-19.9	46.4		
орон нутгийн хөгжлийн сан	63.2	27.3	-35.9	43.2		
дүн	3456.2	3207.2	-249.0	92.8	75.0	15.4

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2153.9 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 992.6 сая төгрөгийг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 69.2 сая төгрөгийг нийт 3156.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Эрүүл мэндийн даатгалаас олгох санхүүжилт 51.4 сая төгрөгөөр дутуу олгогдсон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 165.2 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 53.2 сая төгрөгөөр давсан нь сум хөгжүүлэх сангийн орлого 61.1 сая, Засаг даргын тамгын газрын орлого 1.4 сая, төгрөгөөр давж орсон боловч байгаль хамгаалах сангийн орлого 14.6 сая төгрөгөөр тасарсан зэргээс шалтгаалжээ.

Туслах үйл ажиллагааны орлого 0.4 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 0.4 сая төгрөгөөр давсан нь авлага барагдуулсанаас шалтгаалжээ.

Хүснэгт № 11 Төсвийн гүйцэтгэл хөтөлбөрөөр төгрөг/

/мянган

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
71801/80109	51666.9	51504.7	162.2	99.7
71801/80807	27842.6	13554.0	14288.6	48.7
71801/81834	143589.4	142439.3	1150.1	99.2
71801/81835	154947.3	148984.9	5962.4	96.2
71801/80802	600.0	600.0	0	100.0
71801	378646.2	357082.9	21563.3	94.3
71802/80109	276291.4	274522.8	1768.6	99.4
71802/80802	800.0	800.0	0	100.0
71802/81806	167491.5	152918.0	14573.5	91.3
71802/81834	677059.1	660364.5	16694.6	97.5
71802/81835	374811.2	362054.8	12756.4	96.6
71802/81801	27216.4	23308.9	3907.5	85.6
71802	1523669.6	1473969.0	49700.6	96.7
70105/80101	67228.0	65798.9	1429.1	97.9
70105/80802	200.0	195.0	5	97.5
70105/82201	3000.0	962.3	2037.7	32.1
70105/80825	12469.5	12238.7	230.8	98.1
70105	82897.5	79194.9	3702.6	95.5
70106/80101	317077.5	307672.7	9404.8	97.0
70106/80106	56614.3	54746.9	1867.4	96.7
70106/80802	1000.0	1000.0	0	100.0
70106/81102	39000.0	35043.3	3956.7	89.9
70106/82212	2000.0	2000.0	0	100.0
70106/82801			0	0.0
70106	415691.8	400462.9	15228.9	96.3

71702/80101	125245	123671.4	1573.6	98.7
71702/80802	13492.6	13492.6	0	100.0
71702/80214	1900.0	1899.5	0.5	100.0
71702	140637.6	139063.5	1574.1	98.9
71602/80101	543872.1	488282.4	55589.7	89.8
71602/80109	44281.6	44280.7	0.9	100.0
71602/80302	105503.7	104510.9	992.8	99.1
71602/80802	680.0	670.4	9.6	98.6
71602	694337.4	637744.5	56592.9	91.8
70503/80513	63188.2	27306.0	35882.2	43.2
70106/81405	120000.0	75178.0	44822	62.6
70106/81701	37141.2	17234.7	19906.5	46.4
	3456209.5	3207236.365	248973.1	92.8

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,207.2 сая төгрөг буюу 92.8 хувьтай байгаа нь засгийн газрын хэмнэлтийн бодлоготой холбоотой шалтгаалсан байна. Үүнд: цалин шимтгэл 101.4 сая, хүүхдийн хоол 25.5 сая, урсгал засвар, багаж техник худалдан авах зардал 4.9 сая, бараа үйлчилгээний бусад зардал 25.9 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Хөрөнгө оруулалтын 7 төсөл, арга хэмжээнд 63.2 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 27.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 16.6 сая, гадаад төсөл хөтөлбөрөөс 0 сая, Засгийн газрын нөөц сан/Засаг даргын нөөц хөрөнгө/-аас 5.0 сая, дээд шатны төсвийн захирагчаас 436.2 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4.1 сая, нийт 461.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Хүснэгт 12	Нэмэлт санхүүжилтийн орлого байгууллагаар						мян.төг	
Үзүүлэлт	ЗДТГ	ИТХ	ЕБС	СӨБ	ЭМТ	Соёл	ОНХС	
Нийт орлого								
462.0	75.7	0.1	44.8	0.2	340.9	0.2	0.0	
Нийт зарлага								
447.9	68.9	0.1	44.6	0.2	333.8	0.2	0.0	
Төсөвт төвлөрүүлсэн								
7.0	6.8	0.0	0.2	0.0		0.0	0.0	
үлдэгдэл								
7.06					7.06			

Үүнээс цалин шимтгэл-д 71.0, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 2.6, хангамж бараа материалын зардалд 85.9, эм хоол хүнс нормын хувцсанд 98.2, урсгал засвар багаж техник хэрэгсэлд 40.3, бараа үйлчилгээний бусад зардалд 72.2, тэтгэмж урамшуулалд 56.2, хөрөнгө худалдан авах зардалд 20.5, нийт 447.9 төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 0.2 сая төгрөгийг улсын, 6.7 сая төгрөгийг орон нутгийн и төсөвт төвлөрүүлсэн байна. Мөн эмнэлгийн 7.0 сая төгрөг төрийн сангийн дансанд үлдсэн.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 156 мэдээллээс 156 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

3.7.1 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийлээ. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4, 1.6, 1.7 дэх заалтыг зөрчсөн. /ЗДТГ 6.4 сая, ИТХ 7.5 сая, ЕБС 11.1 сая/

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 4.5 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт №13 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							
Албан шаардлага	1		1				
Зөвлөмж	3	36.6	3	36.6			0
Нийт	4	36.6	4	36.6			

3.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сум хөгжүүлэх сангийн авлагыг журналын бичилтийг аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захирамжаар батлагдсан НБББББ-ын 4.5-д заасны дагуу иргэдээс авах зээлийн авлагыг богино хугацаат авлага, урт хугацаат авлагаар бүртгээгүй зөрчлийг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай байна.

4 Аудитын илрүүлэлт, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгайн сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Зөрчилгүй"-4, "Хязгаарлалттай" -1 /Эрүүл мэндийн газар/ дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 555.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 41.5 сая төгрөгийн 7 алдааг аудитын явцад залруулж, 5.1 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 483.0 сая төгрөгийн 12 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 25.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 9 зөвлөмжийг хүргүүлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн алдаа байхгүй байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт

- 2021 оны малын хөлийн татвар 12.0 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41.2.1-д "хуулийн дагуу улс орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт хүргүүлээ.
- Байгаль хамгаалах сангаас талбай тусгаарлалтын зардал 1.2 сая төгрөгийг зарцуулсан нь 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3 дахь заалттай бүрэн нийцээгүй зөрчилд төлбөрийн акт хүргүүлээ.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт:

1.1. Илрүүлэлт:

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журмын дагуу байгууллагын дотоод хяналтын журамыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулж дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй.

1.2. Өгсөн зөвлөмж

Байгууллагын додоот хяналт шалгалтын журмыг холбогдох журмын дагуу боловёруулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хишиг-Өндөр сумын Засаг дарга	3	13.3			2	13.3			1	0